Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/66 тоот тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй Дотоод хяналтын зөвлөлийг байгуулсан байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга дотоод хяналтын зөвлөлийн 14 арга хэмжээ хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2021 оны 5 сард баталсан ч дотоод хяналтын зөвлөл дотоод хяналтын төлөвлөгөөний дагуу ажиллаагүй, дотоод хяналтыг хийгээгүй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас аймгийн Засаг даргын тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд 2021 онд хяналт шалгалт хийгээгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Засаг даргын Тамгын газар 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 5,002,016.2 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 75,030.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 56,272.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос дахин тооцож үзэхэд гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 95,255.1 мянган төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 20,224.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн тул материаллаг түвшинг дахин тооцов.

Учир нь төлөвлөлтийн үе шатанд тооцсон нийт орлого 5,002,016.2 мянган төгрөг гүйцэтгэлийн үе шатны орлого 6,350,339.8 мянган төгрөг, 1,348,323.6 мянган төгрөгөөр орлого нэмэгдсэн байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Энэхүү Санхүүгийн Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Төв аймгийн Засаг даргын Тамгын газарт мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Орлого:

Тус байгууллага 2021 онд орон нутгийн төсвөөс 1,962,916.6 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 145,322.8 мянган төгрөг, дээд шатны захирагчаас 900,448.0 мянган төгрөг, Засаг даргын нөөц сангаас 2,354,749.2 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 72,952.2 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 832,859.6 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 56,697.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 24,394.0 мянган төгрөг нийт 6,350,339.8 мянган төгрөг өмнөх оноос 1,348,323.6 мянган төгрөгөөр буюу 27%-иар нэмэгдсэн байна.

Зардал :

Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 6,356,374.7 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 6,205,017.0 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 3,450,728.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100140051001 тоот дансанд 2021 онд 4,554,821.6 мянган төгрөгийн орлого, 4,554,821.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна., 100140051418 тоот дансанд 1,837,567.5 мянган төгрөгийн орлого, 1,837,567.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	2,268.2	1,958.0	310.2
Урьдчилгаа			
Бараа материал	153,627.2	149,566.8	4,060.4
Үндсэн хөрөнгө	3,254,191.1	3,252,736.9	-1,454.2
Нийт хөрөнгө	3,410,086.6	3,404,261.7	-5,824.9
Өр төлбөр		210.0	-210.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,410,086.6	3,404,051.7	6,034.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,410,086.6	3,404,261.7	-5,824.9

Авлага дансны оны эхний үлдэгдэл 2,268.2 мянган төгрөгийг барагдуулж, оны эцэст 310.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 149,566.8 мянган төгрөг болж 4,060.4 мянган төгрөгөөр буурсан нь бараа материалыг акталж устгаснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,252,736.9 мянган төгрөг болж 5,824.9 мянган төгрөгөөр буурсан нь акталж устгасан хөрөнгөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь орон нутгийн төсвөөс худалдан авсан 113,995.6 мянган төгрөгийн хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан 87,126.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэн, акталж устгасан 32,385.0 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,404,051.7 мянган төгрөг болж 6,034.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,984,056.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 1,984,056.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 76,735.1 мянган төгрөгөөр бууруулж орон нутгийн төсвөөс 1,907,320.9 мянган төгрөг, Засаг даргын нөөц санг 378,349.2 мянган төгрөг нийт 2,285,670.1 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан байна.

Тус байгууллагын төсвийг аймгийн ИТХ-ын 2021 оны 8 дүгээр сарын 12-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор орон нутгийн төсвөөс 1,907,320.9 мянган төгрөг, Засаг даргын нөөц санг 2,354,749.2 мянган төгрөг нийт 4,262,070.1 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 1,892,320.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 15,000.0 мянган төгрөг, Засаг даргын даргын нөөц санг санхүүжүүлэхээр 2,354,749.2 мянган төгрөгийн төсөв баталснаас нийт 4,262,070.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөв болон өөрийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 4,317,665.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 24,394.0 мянган төгрөг, Засаг даргын нөөц сан болон хуваарилагдаагүй зардлын хоорондын тооцоогоор зөрүү арилгах санхүүжилт 25,879.7 мянган төгрөг нийт 4,367,939.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 3,450,728.0 мянган төгрөгийг зарцуулж, үндсэн үйл ажиллагаанаас 121,169.0 мянган төгрөг, Засаг даргын нөөц сангаас 796,042.5 мянган төгрөг нийт 917,211.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант онд аймгийн ИТХ-ын 2021 оны 08 дүгээр сарын 12-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 4,262,070.1 мянган төгрөгөөр тодотгон баталсан байхад гүйцэтгэлээр 4,317,665.8 мянган төгрөг буюу 55,595.7 мянган төгрөгийн илүү санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,450,728.0 мянган төгрөг буюу 96.36 хувьтай байгаа нь 917,211.5 мянган төгрөг буцаан төвлөрүүлж зарцуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 900,448.0 мянган төгрөг, туслах аж ахуйн орлого 73,974.8 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 832,859.6 мянган төгрөг, Хөгжлийн бодлогын хэлтсээс 29,795.1 мянган төгрөг нийт 1,837,077.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар хог хаягдал зайлуулах, хортон шавж устгах зардалд 259,237.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 72,554.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1,441,915.3 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 7,344.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд 1,160.3 мянган төгрөг, цалингийн зардалд 15,697.6 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл зардалд 2,042.9 мянган төгрөг нийт 1,799,952.0 мянган төгрөг зарцуулж, 37,125.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Засаг даргын Тамгын газар тайлант онд 45,093.8 мянган төгрөгийн барилга байгууламж, 56,100.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 12,801.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нийт 113,995.6 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 19,928.5 мянган төгрөгийн барилга байгууламж, 53,572.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 13,126.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 500.0 мянган төгрөгийн программ хангамж нийт 87,126.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Төв аймгийн Засаг даргын Тамгын газар тайлант онд түргэвчилсэн оношлуурын зардалд 233,645.6 мянган төгрөг, тусгаарлах байрны зардалд 72,600.0 мянган төгрөг, сумдад шатахуун, ковид-19 цар тахлын зардалд 251,000.0 мянган төгрөгийн зардал, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газарт ковид-19 цар тахлын урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 74,809.0 мянган төгрөг, Чихрийн шижинтэй тэмцэх үндэсний төв ТББ эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 12,740.0 мянган төгрөг, аймгийн Шуурхай штаб болон Онцгой байдлын газарт дайчилгаа, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үйл ажиллагааны зардалд 124,388.4 мянган төгрөг нийт 769,183.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Төв аймгийн Засаг даргын Тамгын газар тайлант онд 7 сумын халаалт дулааны зардлын өр барагдуулахаар 166,471.9 мянган төгрөг, 2 сумд шүүхийн шийдвэрээр гарсан өр барагдуулахаар 12,429.3 мянган төгрөг, Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургуулийн А байр, Баян, Баянцагаан сумын сургуулийн гал тогооны засварт 156,581.8 мянган төгрөг, Төрийн бус байгууллагуудын санхүүжилтэд 29,500.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 132 мэдээллээс хугацаандаа оруулсан 119 мэдээлэл, хугацаа хоцроосон 13 мэдээлэл байна. Тус байгууллага 5,0 саяас дээших худалдан авалтын 9 гүйлгээ, 5,0 саяас дээших орлогын 72 гүйлгээ, зарлагын 336 гүйлгээ хугацаандаа байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалын хавсралт “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3-т. Засаг даргын нөөц хөрөнгийг нийт дүнгээр нь “Орон нутгийн нөөц хөрөнгө” гэсэн зориулалтаар Засаг даргын тамгын газрын төсөвт тусган тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулна. гэж заасны дагуу аймгийн Засаг даргын нөөц санг аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолоор 378,349.2 мянган төгрөг баталсныг ИТХ-ын 2021 оны 8 дүгээр сарын 12-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 2,354,749.2 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

Тус байгууллага тайлант онд аймгийн Засаг даргын зарцуулсан нөөц хөрөнгийг Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалын хавсралт “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2-т. “Нөөц хөрөнгийн зарцуулалтын тайланг санхүүжүүлсэн зардал, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсөвтэй зэрэгцүүлэн гаргаж, байгууллагын дарга, нягтлан бодогч нар гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулан холбогдох баримтыг хавсаргана”, 6.3-т. “Нөөц

хөрөнгийн зарцуулалт, тайлагналтыг тухайн шатны Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч хариуцан гүйцэтгэнэ” гэж заасныг баримтлан тайлагнасан байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн данстай холбоотой 1 зөвлөмж, 2 албан шаардлага өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 02/870 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагад балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар Засаг даргын захирамжаар зарцуулж байгаа мөнгөнд анхаарах.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 377,124.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 87,126.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 176,001.9 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 113,995.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгөв.

4.2.1 Залруулсан алдаа

1.Тус байгууллага тайлант оны мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгийн зардалд худалдан авсан биет болон биет бус хөрөнгө 87,126.9 мянган төгрөг тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2.3 Албан шаардлага

1.Худалдан авалт бүрийн е баримт болох анхан шатны төлбөрийн баримтаар баталгаажсан эсэхийг тулган шалгахад 89,545.9 мянган төгрөгийн 46 байгууллагын гүйлгээ е баримтаар баталгаажсаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, батламж мэдэгдлийг хангаж ажиллаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт

тогтоох” журмын 4.2.1.4-д “4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

2. Тус байгууллага 2020 онд хүнсний нөөц бүрдүүлэхээр авсан 50 кг-н 200 ш өөг гурилаас үлдэгдэл 26 уут буюу 1,456.0 мянган төгрөгийн гурилын хугацаа дууссан, хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалтын агуулахад хийгээгүйгээс муудаж хүнсэнд хэрэглэх шаардлага хангахгүй болсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтуудыг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.4-д “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

3. Тайлант онд аймгийн Засаг даргын А/551 тоот захирамжаар 2021 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр Бурам фарм ХХК-аас худалдан авахаар 3000 ш оношлуурын үнэ 51,000.0 мянган төгрөг, А/754 тоот захирамжаар 2021 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Монгол эм импекс ХК-аас худалдан авахаар 1200 ш оношлуурын үнэ 20,400.0 мянган төгрөг, Нэгүн арвижих ХХК-аас худалдан авахаар 800 ш оношлуурын 13,600.0 мянган төгрөг, нийт 85,000.0 мянган төгрөгт 5000 ширхэг түргэвчилсэн оношлуур худалдан авахаар Засаг даргын нөөц сангаас шилжүүлжээ. Аймгийн Засаг даргын захирамжаар “хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж тайлагнахыг аймгийн Эрүүл мэндийн газарт үүрэг болгосон” боловч 85,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан 5000 ширхэг оношлуур Эрүүл мэндийн газрын санхүүгийн тайланд тусгагдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ:” 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.4-д “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

1.Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/66 тоот тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын зөвлөлийг байгуулсан байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга дотоод хяналтын зөвлөлийн 14 арга хэмжээ хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2021 оны 5 сард баталсан ч дотоод хяналтын зөвлөл дотоод хяналтын төлөвлөгөөний дагуу ажиллаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 311 дүгээр тогтоол “аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:Дотоод хяналтын төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах.

Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд оруулбал зохих 132 мэдээллээс хугацаандаа оруулсан 119 мэдээлэл, хугацаа хоцроосон 13 мэдээлэл байна. Тус байгууллага 5,0 саяас дээших худалдан авалтын 9 гүйлгээ, 5,0 саяас дээших орлогын 72 гүйлгээ, зарлагын 336 гүйлгээ хугацаандаа байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангаж ажиллах.

Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Тус байгууллага тайлант онд Засгийн Газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалтыг зөрчин тавилга эд хогшлын зардалд 113,995.6 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг болон

Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	АЗДТГ	6	377,124.4	1	87,126.9			3	176,001.9	2	113,995.6
Дүн		6	377,124.4	1	87,126.9			3	176,001.9	2	113,995.6
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	АЗДТГ	1								1	
Дүн		1								1	
Нийт дүн		7	377,124.4	1	87,126.9			3	176,001.9	3	113,995.6